



# МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1999 оны 9 сар 29 өдөр

Дугаар А-192

Улаанбаатар хот.

"Батхаан" бага сургууль байгуулах  
тухай

1. Монгол Улсын боловсролын тухай хуулийн 16, 17, 28 дугаар зүйл, Бага, дунд боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлийг үндэслэн гадаад хэлний гүнзгийрүүлсэн сургалттай "Батхаан" бага сургууль байгуулахыг үүсгэн байгуулагч /Р.Давнаа/-д зөвшөөрсүгэй.

2. "Батхаан" бага сургуулийг улсын бүртгэлд бүртгэж, сургалт явуулах тусгай зөвшөөрөл, хяналтын үзүүлэлтийг Боловсролын тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан журамд заасны дагуу олгож, сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Боловсролын мэргэжлийн комисс /Д.Хадхүү/ Боловсролын газрын дарга Л.Дорж/, Сүхбаатар дүүргийн засаг дарга Л.Будрагчаа/-д тус тус даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БОГӨӨД  
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД